



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/203

Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 4977720 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай, зарлагдсан дуудлага худалдааны ялагч болсон Энхнямын Орхончимэг (CP87062722)-д тус сумын 6 дугаар баг, Булган гудамжинд боловсролын байгууллагын зориулалтаар 2025м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч (Энхнямын Орхончимэг)-т даалгасугай.

3. Газар эзэмшилтэнд байнгын хяналт тавьж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг сумын Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj/

2326310408